



**ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2018 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 27

Чингис хот

Өргөдөл хянан шалгах
хугацааг сунгах тухай

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын 12, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.2, 2.2.8, 2.3, 2.3.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нотлох баримт дахин гаргуулах шаардлагатай байгаа тул Өмнөдэлгэр сумын иргэн Л.Баярмаагийн өргөдлийн шалгах хугацааг 2018 оны 6 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн 30 хүртэл хоногийн хугацаагаар сунгасугай.

2. Маргааныг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу сунгасан 30 хоногийн дотор шударга, шуурхай шалган шийдвэрлэж, дүгнэлт гарган Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг комиссын дарга /Ж.Гантулгад/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР